

Хөрөнгө Сайжруулах Урьдчилсан Төлөвлөгөөний (CIP) тайланг товч харвал



Хөрөнгө Сайжруулах Урьдчилсан Төлөвлөгөөний (CIP) тайлан буюу өмнө нь Арлингтон хотын барилга байгууламж, сурагчдын байрны төлөвлөгөө (AFSAP) гэж нэрлэгдэж байсан төлөвлөгөөний тайлан өмнөх CIP-д тулгуурласан бөгөөд Сургуулийн ТУЗ-д дараагийн CIP боловсруулахдаа энэ CIP-г харгалзан үзэхийг зөвлөж байгаа юм. Энэ тайлан APS-д дараагийн CIP-н төсөл боловсруулах, APS-ийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг урьдчилан тооцоолсон элсэлтийн өөрчлөлттэй уялдуулах зохицуулалтыг тодорхойлоход тусална. Мөн хил хязгаар, түр орон зайн талаар зөвлөмж гаргах юм. Уг тайлангаар 2023-24, 2024-25 оны хичээлийн жилд хэрэгжих, оролцох боломжтой бүх төслийг тодорхойлох болно. Хөрөнгө Сайжруулах Урьдчилсан Төлөвлөгөөний (CIP)

тайланд санал болгож буй өөрчлөлтөд барилга байгууламж, үйл ажиллагаа, сурагчдын үйлчилгээний үйл ажиллагааны талаар тусгажээ.

Энэхүү тайлан нь дараах APS тайланг дэмжиж байна:

- Элсэлтийн 10 жилийн таамаглал
- Элсэлтийн менежментийн төлөвлөгөө (EMP): EMP буюу өмнө нь Жил тутмын шинэчлэл хэмээн нэрлэгддэг байсан баримт нь үйл ажиллагаанд гарсан шийдвэрийг баримтжуулж, нэр заасан сургуулиудад хийгдэж буй алхмуудыг онцлон тэмдэглэдэг бөгөөд хичээлийн нэг жилээр хязгаарлагддаг тайлан юм.
- Таамаглалын хаврын улиралд гарах шинэчлэлт: Дараа жил ажиллах ажилтнуудын тоог төлөвлөх зорилготой
- Хөрөнгө сайжруулах төлөвлөгөө: 10 жилийн төлөвлөгөөг хоёр жил тутамд шинэчилдэг

2023 оны намрын үйл ажиллагааны зөвлөмж

Дунд сургуулийн элсэлтийн тэнцэл

APS нь дунд сургуулийн сурагчдын тоог зөв зохистой хэмжээнд байлгах, сургуулийн бүх тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлэх, татвар төлөгчдийн санг зохистой хэрэглэх үүднээс дунд сургуулийн хамрах хязгаар тогтоох явц эхлүүлж байна. Уг өөрчлөлт 2025-26 оны хичээлийн жилд хүчин төгөлдөр болох бөгөөд үүнд Дунд сургуулийн хос хэлний вакум сургалтын хөтөлбөрийг Gunston дунд сургуулиас Kenmore дунд сургууль руу шилжүүлэх зөвлөмж багтсан болно. Мөн 2025-26 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэх дунд сургуулийн хамрах хязгаарыг тохируулах явц багтах юм. **Сургуулийн Удирдах зөвлөл 2023 оны арванхоёрдугаар сард дунд сургуулийн хамрах хязгаар тогтоох талаар санал хураалт явуулна.**

Сургуулийн урт хугацааны засварын ажил, түр орон зайг тодорхойлох

Удахгүй болох 2023 оны намрын CIP төслийн чиглэлд нэг бага сургуулийг аль болох хурдан засварлах, энэ үеэр уг сургуулийн сурагчдыг байрлуулах Nottingham бага сургуулийг түр байрлуулах зориулалттай түр орон зай болгон өөрчлөх зөвлөмж багтсан болно. 2025-26 оны хичээлийн жилийн бага сургуулийн хамрах хязгаар тогтоох явцаар 2026-27 оны хичээлийн жилд сурагчдыг ойролцоох сургуулиудад дахин хуваарилах болно. Түр орон зай гэдэг нь сургуулийн барилгын их засварын ажил хийгдэж байгаа үед ашиглах боломжтой байгууламжийг хэлнэ. Тус орон зай нь бага ангийн сурагчдын хэрэгцээг харгалзан үзэж, тэдэнд заах, сурахад шаардлагатай бүх нөөцийг ашиглах боломжийг олгодог. **Сургуулийн Удирдах зөвлөл 2024 оны 6-р сард 2025-34 оны санхүүгийн жилийн CIP-ийн талаар санал хураалт явуулна.**

Арлингтон хотын Карьерын төвийн хотхоныг барьж дуусгах ирээдүйн үе шат

Ахлах ахлагч Сургуулийн Удирдах зөвлөлийн 2023 оны 10-р сарын CIP-н чиглэлд Арлингтон хотын Карьерын төвийн хотхоныг хөгжүүлэх 2-р үе шатны төлөвлөгөөг багтаахыг зөвлөж байна.

- Сурагчдын багтаамж хамгийн ихдээ 2570 суудалтай байлгана



Хөрөнгө Сайжруулах Урьдчилсан Төлөвлөгөөний (CIP) тайланг товч харвал

- Арлингтон хотын Монтессори улсын сургуулийн (MPSA) одоо байгаа ACC барилгын зориулалтыг өөрчилнө
- MPSA (Генригийн барилга)-ыг нурааж, ногоон байгууламжаар солино

2023-32 оны санхүүгийн жилийн CIP-д Арлингтон хотын Карьерын Төвийн (ACC) шинэ хотхоныг хөгжүүлэх хоёрдугаар шатны хөгжүүлэлтийн санхүүжилтийг тусгасан байна. Сургуулийн Удирдах зөвлөлийн CIP чиглэл Арлингтоны Монтессори улсын сургуулийн (MPSA) одоо байгаа ACC барилгыг дахин төлөвлөх төлөвлөгөөг баталгаажуулж, нэмэлт талбай, ногоон байгууламжийн зориулалтаар одоогийн MPSA-г нураах ёстой. Үүнээс гадна энэхүү тайланд дараах зөвлөмжийг нарийвчлан тусгасан болно. **Сургуулийн Удирдах зөвлөл 2024 оны 6-р сард 2025-34 оны санхүүгийн жилийн CIP-ийн талаар санал хураалт явуулна.**

Нэмэлт мэдээлэл болон CIP-ийн өмнөх тайланг бүрэн эхээр нь үзэхийг хүсвэл дараах холбоосоор зочилно уу.

<https://www.apsva.us/engage/pre-cip-report/>